

ГОВЬ-АЛТАЙ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Шарга сумын Засаг даргын Тамгын газрын 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн
гүйцэтгэлд хийсэн аудитын хураангуй тайлан

Аудитын код: ГАА-2026/102/НА-СТА-ТШЗ

Цахим хуудас: www.audit.mn Алтай хот	2026 он	Дарга, тэргүүлэх аудитор: Г.Гүнжидмаа Утас: 99998431 Цахим хаяг: gunjidmaag@audit.gov.mn Аудитын менежер: Д.Эрдэнэчимэг Утас: 99175677 Цахим хаяг: erdenechimegd@audit.gov.mn Ахлах аудитор: М.Атарцэцэг Утас: 88984411 Цахим хаяг: atartsetsegm@audit.gov.mn
--	---------	--

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.



**ГОВЬ-АЛТАЙ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

1402, Хөгжил хороолол, Жинст баг,
Есөнбулаг сум, Говь-Алтай аймаг, 82091
Утас: (976) 7048-4030,
Цахим шуудан: govialtai@audit.gov.mn

ШАРГА СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ТАМГЫН ГАЗРЫН ДАРГЫН АЛБАН
ҮҮРГИЙГ ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ
Б.ХОРЛООЖАВ ТАНАА

2025. 02. 24 № 94
танай _____ -ны № _____ -т

Хязгаарлалттай дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Шарга сумын Засаг даргын Тамгын газрын 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Бидний үзэж байгаагаар Хязгаарлалттай санал дүгнэлтийн үндэслэл хэсэгт тайлбарласан зүйлсийн үр нөлөөг эс тооцвол 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, тайлант жилийн эцсээрх тэдгээрийн санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу бүхий л материаллаг байдлын үүднээс үнэн зөв толилуулсан байна.

Хязгаарлалттай санал дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, шалгадагч этгээдээс хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Санхүүгийн тайлангийн аудитаар илэрсэн доорх зөрчлүүд нь бидний тогтоосон материаллаг байдлын түвшнээс давсан бөгөөд дангаар буюу нийт дүнгээрээ санхүүгийн тайланд материаллаг нөлөөтэй боловч өргөн тархаагүй болно. Үүнд:

- Батлагдсан төсвөөс ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэлийн зардлыг 12,651.4 мянган төгрөгөөр, түлш халаалтын зардлыг 8,303.2 мянган төгрөгөөр тус тус хэтрүүлэн зарцуулсан.
- Өмнөх оны өр төлбөрийг барагдуулаагүй, тайлант онд татвар, нийгмийн даатгалын шимтгэлийн 22,299.4 мянган төгрөгийн, халаалтын 24,631.2 мянган төгрөгийн, бичиг хэрэг, гэрэл цахилгаан, шатахуун, сэлбэг хэрэгслийн 3,713.5 мянган төгрөгийн өр төлбөр нэмэгдэж, нийт 50,644.1 мянган төгрөгийн үлдэгдэлтэй.
- Өвөлжилтийн бэлтгэх байдалтай танилцах ажлаар багийн айл өрхүүдээр явсан шатахуун зарцуулалтыг жолоочийн замын хуудсанд бөөн дүнгээр бичсэн, маршрут

872505000263

зураглалгүй байгаа нь зарцуулалтыг нотлох боломжгүй, Хамтын хүч багийн айл өрхөөр 1700 километр явсан байгаа нь бусад багуудаас 2 дахин их, бодитоор явсан эсэх нь тодорхойгүй.

- Өмч хамгаалах Байнгын зөвлөлийн дүгнэлтгүйгээр 6,498.2 мянган төгрөгийн бараа материалыг акталж данснаас хассан.
- Засаг даргын Тамгын газрын буудлыг түрээслэгчээс 480.0 мянган төгрөгийн, цайны газар түрээслэгчээс 260.0 мянган төгрөгийн түрээсийн төлбөрийг төвлөрүүлээгүй.
- Тайлант онд тус байгууллага 760.0 мянган төгрөгийн өөрийн орлогыг төвлөрүүлсэн боловч үйл ажиллагааны орлогыг төлөвлөөгүй.

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1, 6.4.8, 16 дугаар зүйлийн 16.5.4, 27 дугаар зүйлийн 27.1.7, 41 дүгээр зүйлийн 41.2.1, 41.2.2, 41.2.7, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1, 20 дугаар зүйлийн 20.2.5, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2019 оны 271 дүгээр тогтоолын хавсралтаар баталсан "Төрийн болон орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх журам"-ын 2 дугаар зүйлийн 2.1.3, тус газрын 2022 оны 65 дугаар тогтоолын хавсралт "Төрийн өмчит хуулийн этгээдийн өмч хамгаалах Байнгын зөвлөлийн үйл ажиллагааны журам"-ын 5.1 дэх заалттай тус тус нийцээгүй, санхүүгийн тайлагналын иж бүрэн байх, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна

Асуудлыг онцолсон хэсэг

Тус байгууллагаас тайлант онд сонгуулийн үр дүнгээр ажлаасаа чөлөөлөгдсөн сумын Засаг дарга, 4 багийн Засаг даргад хууль тогтоомжид заасны дагуу 47,198,0 мянган төгрөгийн тэтгэмж олгосон байна.

Тайлант онд төсвийн хөрөнгөөр бэлтгэсэн 3,549.0 мянган төгрөгийн, аймаг, сумын Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгө, бусад эх үүсвэрээс 966,572.1 мянган төгрөгийн үндсэн хөрөнгийг орлогод авсан байна.

Аудитын гол асуудал

Өмнөх оны өглөгийг барагдуулаагүй, төрийн сангаас зардал хязгаарласантай холбоотойгоор 50,644.1 мянган төгрөгийн өр төлбөртэй байна.

Бусад асуудлын хэсэг

Тайлант онд 3 зорилтын хүрээнд 112 арга хэмжээ хэрэгжүүлэхээр аймгийн Засаг даргатай гүйцэтгэлийн төлөвлөгөө байгуулан, гүйцэтгэлээр 86.7 хувиар дүгнүүлжээ.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ
АУДИТОР



ГҮНЖИДМАА

2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан СТ-1 (төгрөгөөр)

БАЛАНСЫН ЗҮЙЛ	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	185,696,617.00	180,782,317.00
АВЛАГА	8,406,669.00	624,669.00
Татаас, санхүүжилтийн авлага	8,164,469.00	624,669.00
БАРАА МАТЕРИАЛ	177,289,948.00	180,157,648.00
Түүхий эд материал	8,388,583.00	13,418,583.00
Тусгай зориулалттай материал	8,388,583.00	13,418,583.00
Хангамжийн материал	21,941,265.00	19,940,065.00
Бичиг хэргийн материал	91,200.00	245,000.00
Аж ахуйн материал	21,850,065.00	19,695,065.00
Мал амьтад	146,960,100.00	146,799,000.00
ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	9,969,580,280.00	10,594,451,138.49
ҮНДСЭН ХӨРӨНГӨ	9,969,580,280.00	10,594,451,138.49
Биет хөрөнгө	1,929,935,280.04	2,555,921,138.49
Барилга, байгууламж, орон сууц	1,195,283,749.07	2,012,123,738.95
Хуримтлагдсан элэгдэл	(291,023,228.38)	(346,233,574.32)
Авто-тээврийн хэрэгсэл	113,022,000.00	181,194,800.00
Хуримтлагдсан элэгдэл	(84,792,655.62)	(92,246,189.16)
Машин тоног төхөөрөмж (компьютер)	207,358,159.00	158,724,819.93
Хуримтлагдсан элэгдэл	(119,342,727.92)	(102,880,325.96)
Тавилга, аж ахуйн эд хогшил	67,146,892.00	69,386,892.00
Хуримтлагдсан элэгдэл	(10,465,546.72)	(25,645,347.56)
Зам, гүүрийн байгууламж	87,399,696.00	87,399,696.00
Хуримтлагдсан элэгдэл	(34,175,522.06)	(40,898,575.58)
Бусад үндсэн хөрөнгө	1,192,819,558.00	1,240,192,030.00
Хуримтлагдсан элэгдэл	(393,295,093.33)	(585,196,825.81)
Биет бус хөрөнгө	8,039,644,999.96	8,038,530,000.00
Программ хангамж	2,230,000.00	2,230,000.00
Хуримтлагдсан элэгдэл	(1,115,000.04)	(2,230,000.00)
Бусад биет бус хөрөнгө	8,038,530,000.00	8,038,530,000.00
НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	10,155,276,897.00	10,775,233,455.49
НИЙТ ӨР ТӨЛБӨР	86,938,510.23	50,644,123.87
БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	86,938,510.23	50,644,123.87
Өглөг	86,938,510.23	50,644,123.87
Ажилчидтай холбогдсон өглөг	46,856,787.23	22,299,359.87
Бараа үйлчилгээний зардлын өглөг	37,188,217.00	26,389,358.00
Бусад өглөг	2,893,506.00	1,955,406.00
Байгууллагад төлөх өглөг	2,893,506.00	1,611,406.00
Хувь хүмүүст төлөх өглөг	-	344,000.00
ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	10,068,338,386.77	10,724,589,331.62
Засгийн газрын хувь оролцоо	10,068,338,386.77	10,724,589,331.62
Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	274,846,668.74	274,846,668.74

**Шарга сумын Засаг даргын Тамгын газрын 2025 оны санхүүгийн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын хураангуй тайлан**

Өмч: - төрийн	274,846,668.74	274,846,668.74
Хуримтлагдсан үр дүн	9,743,557,153.10	10,405,269,273.64
Өмнөх үеийн үр дүн	9,473,430,497.24	9,749,018,328.79
Тайлант үеийн үр дүн	270,126,655.86	656,250,944.85
Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	49,934,564.93	44,473,389.24
ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	10,155,276,897.00	10,775,233,455.49

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан СТ-2 (төгрөгөөр)

ҮЗҮҮЛЭЛТ	ӨМНӨХ ОН	ТАЙЛАНТ ОН
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	1,356,252,857.88	1,938,434,945.58
ТАТВАРЫН БУС ОРЛОГО	498,506,150.00	984,484,099.50
Нийтлэг татварын бус орлого	498,506,150.00	984,484,099.50
Төсөв байгууллагын өөрийн орлого	40,425,000.00	4,657,000.00
Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	925,000.00	4,657,000.00
Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Үндсэн хөрөнгө	441,581,150.00	979,372,099.50
Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Бараа материал	16,500,000.00	455,000.00
ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	857,746,707.88	953,950,846.08
Нэмэлт санхүүжилтийн орлого	131,655,034.00	12,903,227.00
Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	130,997,307.00	12,903,227.00
Орон нутгийн төсвөөс санхүүжих	726,091,673.88	941,047,619.08
Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	726,091,673.88	941,047,619.08
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	1,086,126,202.02	1,282,184,000.73
УРСГАЛ ЗАРДАЛ	1,086,126,202.02	1,282,184,000.73
БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,061,126,804.18	1,180,620,353.60
Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	536,348,756.97	591,373,835.91
Үндсэн цалин	353,254,454.79	305,614,061.53
Нэмэгдэл	151,969,738.18	210,886,000.00
Унаа хоолны хөнгөлөлт	4,889,226.00	10,539,790.00
Урамшуулал	9,660,000.00	22,786,344.19
Гэрээт ажлын хөлс	16,575,338.00	41,547,640.19
Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	55,195,800.00	66,901,000.00
Тэтгэврийн даатгал	38,328,400.00	44,164,400.00
Тэтгэмжийн даатгал	4,216,300.00	5,684,100.00
ҮОМШӨ-ний даатгал	2,108,700.00	2,842,100.00
Ажилгүйдлийн даатгал	2,108,700.00	2,842,100.00
Эрүүл мэндийн даатгал	8,433,700.00	11,368,300.00
Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	84,023,153.30	72,098,301.68
Гэрэл, цахилгаан	6,612,220.30	11,358,150.00
Түлш, халаалт	77,410,933.00	60,740,151.68
Хангамж, бараа материалын зардал	35,511,167.00	33,024,235.00
Бичиг хэрэг	3,600,300.00	3,641,500.00
Тээвэр, шатахуун	27,734,300.00	21,860,101.00
Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	2,183,840.00	1,842,034.00
Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	1,962,727.00	5,680,600.00

Эд хогшил, урсгал засварын зардал	104,000.00	2,044,000.00
Урсгал засвар	104,000.00	2,044,000.00
Томилолт, зочны зардал	11,290,000.00	9,420,000.00
Дотоод албан томилолт	11,290,000.00	9,420,000.00
Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	20,883,723.00	21,134,440.00
Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	19,423,347.00	20,107,676.00
Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	550,000.00	403,200.00
Тээврийн хэрэгслийн татвар	90,376.00	123,564.00
Тээврийн хэрэгслийн оношилгоо	-	35,000.00
Мэдээлэл, технологийн үйлчилгээ	520,000.00	465,000.00
Бараа үйлчилгээний бусад зардал	317,770,203.91	384,624,541.01
Бараа үйлчилгээний бусад зардал	40,504,700.00	25,494,300.00
Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	100,000.00	1,080,000.00
Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	277,165,503.91	358,050,241.01
УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	24,999,397.84	101,563,647.13
Бусад урсгал шилжүүлэг	24,959,449.20	96,213,365.00
Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	24,059,449.20	95,863,365.00
Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	900,000.00	350,000.00
Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	39,948.64	5,350,282.13
Төвлөрүүлэх шилжүүлэг	39,948.64	5,350,282.13
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	270,126,655.86	656,250,944.85
НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	270,126,655.86	656,250,944.85

2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

СТ-3

(төгрөгөөр)

ҮЗҮҮЛЭЛТ	ӨМНӨХ ОН	ТАЙЛАНТ ОН
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	858,671,707.88	967,014,515.08
ТАТВАРЫН БУС ОРЛОГО	925,000.00	4,657,000.00
Нийтлэг татварын бус орлого	925,000.00	4,657,000.00
Төсөв байгууллагын өөрийн орлого	925,000.00	4,657,000.00
Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	925,000.00	4,657,000.00
ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	857,746,707.88	962,357,515.08
Нэмэлт санхүүжилтийн орлого	131,655,034.00	21,309,896.00
Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	130,997,307.00	12,903,227.00
Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	657,727.00	8,406,669.00
Орон нутгийн төсвөөс санхүүжих	726,091,673.88	941,047,619.08
Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	726,091,673.88	941,047,619.08
НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	753,147,376.88	964,015,515.08
УРСГАЛ ЗАРДАЛ	753,147,376.88	964,015,515.08
БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	719,983,510.04	861,827,198.95
Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	489,491,969.74	593,340,063.27
Үндсэн цалин	306,397,667.56	285,308,800.00
Нэмэгдэл	151,969,738.18	210,886,000.00
Унаа хоолны хөнгөлөлт	4,889,226.00	12,887,263.27
Урамшуулал	9,660,000.00	22,860,000.00

**Шарга сумын Засаг даргын Тамгын газрын 2025 оны санхүүгийн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын хураангуй тайлан**

Гэрээт ажлын хөлс	16,575,338.00	61,398,000.00
Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	55,195,800.00	89,492,200.00
Тэтгэврийн даатгал	38,328,400.00	66,755,600.00
Тэтгэмжийн даатгал	4,216,300.00	5,684,100.00
ҮОМШӨ-ний даатгал	2,108,700.00	2,842,100.00
Ажилгүйдлийн даатгал	2,108,700.00	2,842,100.00
Эрүүл мэндийн даатгал	8,433,700.00	11,368,300.00
Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	55,683,968.30	82,897,160.68
Гэрэл, цахилгаан	5,530,232.30	9,600,000.00
Түлш, халаалт	50,153,736.00	73,297,160.68
Хангамж, бараа материалын зардал	30,190,622.00	25,429,535.00
Бичиг хэрэг	3,685,000.00	3,400,300.00
Тээвэр, шатахуун	24,013,782.00	19,610,201.00
Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	2,183,840.00	1,842,034.00
Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	200,000.00	577,000.00
Нормативт зардал	-	1,200,000.00
Нормын хувцас, зөөлөн эдлэл	-	1,200,000.00
Эд хогшил, урсгал засварын зардал	7,915,727.00	2,000,000.00
Урсгал засвар	7,915,727.00	2,000,000.00
Томилолт, зочны зардал	11,290,000.00	9,420,000.00
Дотоод албан томилолт	11,290,000.00	9,420,000.00
Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	26,057,723.00	21,724,440.00
Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	24,597,347.00	20,697,676.00
Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	550,000.00	403,200.00
Тээврийн хэрэгслийн татвар	90,376.00	123,564.00
Тээврийн хэрэгслийн оношилгоо	-	35,000.00
Мэдээлэл, технологийн үйлчилгээ	520,000.00	465,000.00
Бараа үйлчилгээний бусад зардал	44,157,700.00	36,323,800.00
Бараа үйлчилгээний бусад зардал	44,057,700.00	35,243,800.00
Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	100,000.00	1,080,000.00
УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	33,163,866.84	102,188,316.13
Бусад урсгал шилжүүлэг	24,959,449.20	96,213,365.00
Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	24,059,449.20	95,863,365.00
Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	900,000.00	350,000.00
Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	8,204,417.64	5,974,951.13
Төвлөрүүлэх шилжүүлэг	39,948.64	5,350,282.13
Нэмэлт санхүүжилт төвлөрүүлэх шилжүүлэг	8,164,469.00	624,669.00
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	105,524,331.00	2,999,000.00
ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)	105,524,331.00	2,999,000.00
ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	105,524,331.00	2,999,000.00
Дотоод эх үүсвэрээр	105,524,331.00	2,999,000.00
Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	105,524,331.00	2,999,000.00
ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)	(105,524,331.00)	(2,999,000.00)

2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан СТ-4

(төгрөгөөр)

Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
2024 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	274,846,668.74	49,934,564.93	9,473,430,497.24	9,798,211,730.91
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	0.00	0.00	0.00	0.00
Дахин илэрхийлсэн үлдэгдэл	274,846,668.74	49,934,564.93	9,473,430,497.24	9,798,211,730.91
Тайлант үеийн үр дүн	0.00	0.00	270,126,655.86	270,126,655.86
2024 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	274,846,668.74	49,934,564.93	9,743,557,153.10	10,068,338,386.77
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	0.00	0.00	5,461,175.69	5,461,175.69
Дахин илэрхийлсэн үлдэгдэл	274,846,668.74	49,934,564.93	9,749,018,328.79	10,073,799,562.46
Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт	0.00	-5,461,175.69	0.00	-5,461,175.69
Тайлант үеийн үр дүн	0.00	0.00	656,250,944.85	656,250,944.85
2025 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	274,846,668.74	44,473,389.24	10,405,269,273.64	10,724,589,331.62

2.5.1 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан СТ-4-1

(төгрөгөөр)

Код	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	935,385,800.00	936,457,336.95	(1,071,536.95)	100.1%
21	УРСГАЛ ЗАРДАЛ	935,385,800.00	936,457,336.95	(1,071,536.95)	100.1%
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	837,435,800.00	840,243,971.95	(2,808,171.95)	100.3%
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	593,413,700.00	593,340,063.27	73,636.73	100.0%
210101	Үндсэн цалин	310,308,800.00	307,580,288.89	2,728,511.11	99.1%
210102	Нэмэгдэл	185,886,000.00	210,886,000.00	(25,000,000.00)	113.4%
210103	Унаа хоолны хөнгөлөлт	12,960,900.00	10,539,790.00	2,421,110.00	81.3%
210104	Урамшуулал	22,860,000.00	22,786,344.19	73,655.81	99.7%
210105	Гэрээт ажлын хөлс	61,398,000.00	41,547,640.19	19,850,359.81	67.7%
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	76,840,800.00	89,492,200.00	(12,651,400.00)	116.5%
210201	Тэтгэврийн даатгал	54,074,400.00	66,755,600.00	(12,681,200.00)	123.5%

**Шарга сумын Засаг даргын Тамгын газрын 2025 оны санхүүгийн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын хураангуй тайлан**

210202	Тэтгэмжийн даатгал	5,691,600.00	5,684,100.00	7,500.00	99.9%
210203	ҮОМШӨ-ний даатгал	4,554,000.00	2,842,100.00	1,711,900.00	62.4%
210204	Ажилгүйдлийн даатгал	1,137,600.00	2,842,100.00	(1,704,500.00)	249.8%
210205	Эрүүл мэндийн даатгал	11,383,200.00	11,368,300.00	14,900.00	99.9%
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	74,794,000.00	82,897,160.68	(8,103,160.68)	110.8%
210301	Гэрэл, цахилгаан	9,600,000.00	9,600,000.00	-	100.0%
210302	Түлш, халаалт	64,994,000.00	73,297,160.68	(8,303,160.68)	112.8%
210303	Цэвэр, бохир ус	200,000.00	-	200,000.00	0.0%
2104	Хангамж, бараа материалын зардал	30,320,000.00	22,943,684.00	7,376,316.00	75.7%
210401	Бичиг хэрэг	4,000,000.00	2,568,300.00	1,431,700.00	64.2%
210402	Тээвэр, шатахуун	23,000,000.00	18,076,350.00	4,923,650.00	78.6%
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1,920,000.00	1,722,034.00	197,966.00	89.7%
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	400,000.00	-	400,000.00	0.0%
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	1,000,000.00	577,000.00	423,000.00	57.7%
2105	Нормативт зардал	1,247,300.00	1,200,000.00	47,300.00	96.2%
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	1,247,300.00	1,200,000.00	47,300.00	96.2%
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	5,000,000.00	4,999,000.00	1,000.00	100.0%
210601	Багаж, техник, хэрэгсэл	2,000,000.00	2,999,000.00	(999,000.00)	150.0%
210602	Тавилга	1,000,000.00	-	1,000,000.00	0.0%
210604	Урсгал засвар	2,000,000.00	2,000,000.00	-	100.0%
2107	Томилолт, зочны зардал	15,000,000.00	9,420,000.00	5,580,000.00	62.8%
210702	Дотоод албан томилолт	15,000,000.00	9,420,000.00	5,580,000.00	62.8%
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	10,320,000.00	7,628,064.00	2,691,936.00	73.9%
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	7,500,000.00	6,601,300.00	898,700.00	88.0%
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	1,100,000.00	403,200.00	696,800.00	36.7%
210803	Даатгалын үйлчилгээ	315,000.00	-	315,000.00	0.0%

**Шарга сумын Засаг даргын Тамгын газрын 2025 оны санхүүгийн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын хураангуй тайлан**

210804	Тээврийн хэрэгслийн татвар	150,000.00	123,564.00	26,436.00	82.4%
210805	Тээврийн хэрэгслийн оношилгоо	105,000.00	35,000.00	70,000.00	33.3%
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	650,000.00	465,000.00	185,000.00	71.5%
210807	Газрын төлбөр	500,000.00	-	500,000.00	0.0%
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	30,500,000.00	28,323,800.00	2,176,200.00	92.9%
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	30,000,000.00	27,243,800.00	2,756,200.00	90.8%
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	500,000.00	1,080,000.00	(580,000.00)	216.0%
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	97,950,000.00	96,213,365.00	1,736,635.00	98.2%
2132	Бусад урсгал шилжүүлэг	97,950,000.00	96,213,365.00	1,736,635.00	98.2%
213204	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	96,950,000.00	95,863,365.00	1,086,635.00	98.9%
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	1,000,000.00	350,000.00	650,000.00	35.0%
	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	935,385,800.00	941,807,619.08	(6,421,819.08)	100.7%
1320	ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	935,385,800.00	941,047,619.08	(5,661,819.08)	100.6%
132001	Орон нутгийн төсвөөс	935,385,800.00	941,047,619.08	(5,661,819.08)	100.6%
120004	ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС	-	760,000.00	-	
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлого	-	760,000.00	-	
4	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-	-	-	
5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	-	-	-	

2.5.2 Нэмэлт санхүүжилтийн тайлан

(төгрөгөөр)

Код	Үзүүлэлт	Гүйцэтгэл
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	25,206,896.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	25,206,896.00
	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	25,206,896.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	24,582,227.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	24,582,227.00
2104	Хангамж, бараа материалын зардал	2,485,851.00
210401	Бичиг хэрэг	832,000.00

210402	Тээвэр, шатахуун	1,533,851.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	120,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	14,096,376.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	14,096,376.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	8,000,000.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	8,000,000.00
2133	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	624,669.00
213305	Нэмэлт санхүүжилт төвлөрүүлэх шилжүүлэг	624,669.00

3. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар 929,824.8 мянган төгрөгийн бүртгэл тайлагналын алдаа¹-г аудитын явцад залруулж, баталгаажуулав.

Залруулсан алдаа

- **Нягтлан бодох бүртгэлтэй холбоотой:** Ажилчдад 805.9 мянган төгрөгийн цалингийн нэмэгдэл илүү тооцож олгосон,
- Тайлант онд үүссэн 3,981.3 мянган төгрөгийн авлагыг тайлагнаагүй,
- Санхүүгийн үр дүнгийн тайланд урсгал засвар, бараа үйлчилгээний зардлыг 1,994.0 мянган төгрөгөөр зөрүүтэй тайлагнасан,
- Мөнгөн гүйлгээний тайланд бичиг хэрэг, тээвэр шатахууны зардлыг 675.6 мянган төгрөгөөр зөрүүтэй тайлагнасан,
- Түлш халаалтын зардлын өглөгийг 484.8 мянган төгрөгөөр илүү тус тус дутуу тайлагнасныг залрууллаа.
- **Мэдээлэл орхигдуулсантай холбоотой:** Шилэн дансны цахим системд 5 сая төгрөгөөс дээш орлогын 919,097.6 мянган төгрөгийн 41 гүйлгээ, 6,766.9 мянган төгрөгийн 2 тушаал мэдээлээгүйг нөхөн байршуулсан.

Залруулагдаагүй 28,952.8 мянган төгрөгийн зөрчил нь тогтоосон ерөнхий материаллаг байдлын түвшнээс бага байгаа тул "Хязгаарлалттай" дүгнэлт өгсөн.

Аудитаар нийт 28,952.8 мянган төгрөгийн 6 зөрчил² илэрч 1 төлбөрийн акт, 5 зөвлөмж хүргүүллээ.

3.1 Төлбөрийн акт

Засаг даргын Тамгын газрын буудлыг түрээсийн гэрээгээр түрээслэгч Х.Батнасан 480.0 мянган төгрөгийн, гуанз түрээсийн гэрээгээр түрээслэгч Н.Мөнхзаяа 260.0 мянган төгрөгийн түрээсийн төлбөрийг төвлөрүүлээгүй нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.4-т "Төсвийн байгууллагын үйл ажиллагааны үр дүнг дээшлүүлэх", 41 дүгээр зүйлийн 41.2.1-т "Хуулийн дагуу улс, орон нутгийн төсөвт оруулах болон тухайн төсвийн байгууллагын өөрийн үйл ажиллагааны орлогыг бүрэн төвлөрүүлэх", 2025 оны 07 дугаар сарын 01-ний өдрийн 01 дугаартай Х.Батнасан, Н.Мөнхзаяа нартай байгуулсан "Түрээсийн гэрээ"-нд заасантай нийцэхгүй, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Гэрээнд заасан хугацаанд төлөөгүй 740.0 мянган төгрөгийг Төрийн сан дахь Тамгын газрын нэмэлт санхүүжилтийн орлогын 100051655001 тоот дансанд төвлөрүүлэх төлбөрийн акт хүргүүлсэн.

3.2 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

¹ Мэдээллийг тусгахгүй орхигдуулах, буруу тусган илэрхийлэх, үүнд, математик үйлдлийн алдаа, НББ-ийн бодлогыг мөрдөхөд гарсан алдаа, бодит байдлыг буруу тайлбарласан /буруу ойлгосон/, хайнга хандсан

² Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

Нэг. Тээвэр шатахууны зарцуулалттай холбоотой асуудал

Илрүүлэлт: Өвөлжилтийн бэлтгэл ажилтай танилцах ажлаар багийн айл өрхүүдээр явсан шатахуун зарцуулалтыг жолоочийн замын хуудсанд бөөн дүнгээр бичсэн, маршрут зураглалгүй нь зарцуулалтыг нотлох боломжгүй, Хамтын хүч багийн айл өрхөөр 1700 километр явсан байгаа нь бусад багуудаас 2 дахин их, бодитоор явсан эсэх нь тодорхойгүй байгаа нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-т "Төсвийг үр ашигтай хэмнэлттэй байхаар төлөвлөж зарцуулах", 41 дүгээр зүйлийн 41.2.7-т "Хөтөлбөрийн хэрэгжилтэд хяналт тавих, хүрэх үр дүнг хангаж ажиллах", Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1-т "Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн, зөв гаргах үндэслэл болно" гэж заасантай нийцэхгүй, санхүүгийн тайлагналын иж бүрэн, тасалбар болголт, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Өгсөн зөвлөмж: Тээвэр шатахууны зарцуулалтыг хүчин төгөлдөр анхан шатны баримтыг үндэслэн тооцож байх, хяналт тавих, үр ашиг, үр нөлөөг дээшлүүлэх

Хоёр. Өмч хөрөнгөтэй холбоотой

Илрүүлэлт: Өмч хамгаалах Байнгын зөвлөлийн дүгнэлтгүйгээр 6,498.2 мянган төгрөгийн бараа материалыг акталж данснаас хассан Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2019 оны 271 дүгээр тогтоолын хавсралтаар баталсан "Төрийн болон орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх журам"-ын 2 дугаар зүйлийн 2.1.3-т "хуулийн этгээдийн өмч хамгаалах Байнгын зөвлөлийн хурлын тэмдэглэл", Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2022 оны 65 дүгээр тогтоолын хавсралт "Төрийн өмчит хуулийн этгээдийн өмч хамгаалах Байнгын зөвлөлийн үйл ажиллагааны журам"-ын 5.1-т "Зөвлөл нь Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуульд заасны дагуу хуулийн этгээдийн эд хөрөнгө олж авах, бүртгэх, худалдах, шилжүүлэх, акталж данснаас хасах зэрэг эд хөрөнгийн зохицуулалт, орон нутгийн өмчийн үр ашгийг дээшлүүлэх асуудлыг судалж, санал, зөвлөмж, дүгнэлт гаргана" гэж заасантай нийцэхгүй, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Өгсөн зөвлөмж: Хөрөнгө олж авах, бүртгэх, шилжүүлэх, акталж данснаас хасах, дахин үнэлгээ хийх зэрэг эд хөрөнгийн зохицуулалт, хөрөнгийн үр ашгийг дээшлүүлэх асуудлыг байгууллагын Өмч хамгаалах Байнгын зөвлөлөөр хэлэлцүүлж дүгнэлт, зөвлөмж гаргуулж ажиллах.

Гурав.Өглөгтэй холбоотой

Илрүүлэлт: Өмнөх оны өр төлбөрийг барагдуулаагүй, тайлант онд татвар, нийгмийн даатгалын шимтгэлийн 22,299.4 мянган төгрөгийн, халаалтын 24,631.2 мянган төгрөгийн, бичиг хэрэг, гэрэл цахилгаан, шатахуун, сэлбэг хэрэгслийн 3,713.5 мянган төгрөгийн өр төлбөр нэмэгдэж, нийт 50,644.1 мянган төгрөгийн үлдэгдэлтэй нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.8-т "Төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх", Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.5-т "дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах," гэж заасантай тус тус нийцэхгүй, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Өгсөн зөвлөмж: Тайлант онд үүссэн өглөгийг шийдвэрлэн, төсвийн төсөл, санхүүгийн тайланд өглөгийг бүрэн тусгаж байх.

Дөрөв.Батлагдсан төсөв гүйцэтгэлтэй холбоотой

Илрүүлэлт: Батлагдсан төсвөөс ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэлийн зардлыг 12,651.4 мянган төгрөгөөр, түлш халаалтын зардлыг 8,303.2 мянган төгрөгөөр тус тус хэтрүүлэн зарцуулсан нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.8-т "Төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх", 41 дүгээр зүйлийн 41.2.2-т "батлагдсан төсвийн хүрээнд зарлага гаргах", Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.5-т "дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас

нь өмнө хянан, баталгаажуулах;" гэж заасантай тус тус нийцэхгүй, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Өгсөн зөвлөмж: Батлагдсан төсвийн хүрээнд төсвийн зарцуулж байх.

Тав. Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэлтэй холбоотой

Илрүүлэлт: Тайлант онд тус байгууллага 760.0 мянган төгрөгийн өөрийн орлогыг төвлөрүүлсэн боловч үйл ажиллагааны орлогыг төлөвлөөгүй нь Төсвийн тухай хуулийн 27 дугаар зүйлийн 27.1.7-т "орлого, зарлагыг дотоод гүйлгээнээс бусад нийт гүйлгээний дүнгээр төлөвлөж, бүртгэж, тайлагнах" гэж заасантай тус тус нийцэхгүй, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Өгсөн зөвлөмж: Байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон орлогыг төлөвлөж, бүртгэж, тайлагнаж байх.

Дээрх зөвлөмжийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг тайлан хүлээн авснаас хойш 30 хоногийн дотор, биелэлтийг Говь-Алтай аймаг дахь Төрийн аудитын газарт 2026 оны 11 дүгээр сарын 30-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

Шарга сумын Засаг даргын Тамгын газрын 2025 оны санхүүгийн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын хураангуй тайлан

4. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

4.1 Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

(мянган төгрөгөөр)

Аудитад хамрагдсан байгууллагын нэр	Алдааны утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс:			
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Залруулсан		Залруулаагүй	
								тоо	Дүн	тоо	Дүн
1	2	3	4	5	6	7	8	9	10	11	12
Шарга сумын Засаг даргын Тамгын газар	Санхүүгийн үр дүнгийн тайланд урсгал засвар, бараа үйлчилгээний зардлыг 1,994.0 мянган төгрөгөөр зөрүүтэй тайлагнасан.	1	1,994.0	-	-	1	1,994.00	1	1,994.0	-	-
	Мөнгөн гүйлгээний тайланд бичиг хэрэг, тээвэр шатахууны зардлыг 675.6 мянган төгрөгөөр зөрүүтэй тайлагнасан.	1	675.6	-	-	1	675.60	1	675.6	-	-
	Түлш халаалтын зардлын өглөгийг 484.8 мянган төгрөгөөр илүү тайлагнасан	1	484.8	-	-	1	484.80	1	484.8	-	-
	Шилэн дансны цахим хуудсанд санхүүгийн тайланд хийсэн аудитын дүгнэлт, 5 сая төгрөгөөс дээш орлогын 919,097.6 мянган төгрөгийн 41 гүйлгээ, 6,766.9 мянган төгрөгийн 2 тушаал шийдвэрийг мэдээлээгүй.	1	925,864.5	1	925,864.5	-	-	1	925,864.5	-	-
	Ажилчдад 805.9 мянган төгрөгийн цалингийн нэмэгдэл илүү тооцож олгосон.	1	805.9	1	805.9	-	-	1	805.9	-	-
Дүн	5	929,824.8	2.0	926,670.4	3	3,154.4	5	929,824.8	-	-	



Шарга сумын Засаг даргын Тамгын газрын 2025 оны санхүүгийн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын хураангуй тайлан

4.2 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан санхүүгийн аудитын асуудал (мянган төгрөгөөр)

Аудитад хамрагдсан байгууллагын нэр	Алдаа, зөрчлийн товч утга	Нийт алдаа, зөрчлийн дүн		Үүнээс:					
		Тоо	Дүн	Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
				Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
1	2	3	4	5	6	7	8	9	10
	Засаг даргын Тамгын газрын буудлыг түрээсийн гэрээгээр түрээслэгч Х.Батнасан 480.0 мянган төгрөгийн, гуанз түрээсийн гэрээгээр түрээслэгч Н.Мөнхзаяа 260.0 мянган төгрөгийн түрээсийн төлбөрийг төвлөрүүлээгүй.	1	740.0	1	740.0	-	-	-	-
Шарга сумын Засаг даргын Тамгын газар	Өвөлжилтийн бэлтгэл ажилтай танилцах ажлаар багийн айл өрхүүдээр явсан шатахуун зарцуулалтыг жолоочийн замын хуудсанд бөөн дүнгээр бичсэн, маршрут зураглал байхгүй байгаа нь зарцуулалтыг нотлох боломжгүй байна. Мөн Хамтын хүч багийн айл өрхөөр 1700 километр явсан байгаа нь бусад багуудаас 2 дахин их, бодитоор явсан эсэх нь тодорхойгүй.	1	-	-	-	-	-	1	-
	Өмч хамгаалах Байнгын зөвлөлийн дүгнэлтгүйгээр 6,498.2 мянган төгрөгийн бараа материалыг акталж данснаас хассан.	1	6,498.2					1	6,498.2
	Өмнөх оны өр төлбөрийг барагдуулаагүй, тайлант онд татвар, нийгмийн даатгалын шимтгэлийн 22,299.4 мянган төгрөгийн, халаалтын 24,631.2 мянган төгрөгийн, бичиг хэрэг, гэрэл цахилгаан, шатахуун, сэлбэг хэрэгслийн 3,713.5 мянган төгрөгийн өр төлбөр нэмэгдэж, нийт 50,644.1 мянган төгрөгийн үлдэгдэлтэй.	1	-					1	
	Батлагдсан төсвөөс ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэлийн зардлыг 12,651.4 мянган төгрөгөөр, түлш халаалтын зардлыг 8,303.2 мянган төгрөгөөр тус тус хэтрүүлэн зарцуулсан.	1	20,954.60					1	20,954.60
	Тайлант онд тус байгууллага 760.0 мянган төгрөгийн өөрийн орлогыг төвлөрүүлсэн боловч үйл ажиллагааны орлогыг төлөвлөөгүй.	1	760.00					1	760.00
	Нийт	6	28,952.80	1	740.0	0	-	5	28,212.80



5. ТӨСВИЙН ЗАХИРАГЧИЙН АНГИЛЛААР АУДИТАД ХАМРАГДСАН БАЙДАЛ БА САНАЛ ДҮГНЭЛТИЙН ТАЛААРХ МЭДЭЭЛЛИЙН НЭГТГЭЛ

№	Төсвийн захирагчийн ангилал	Байгууллага, нэгжийн тоо					Санал дүгнэлтийн хэлбэр			
		Аудитад хамрагдах	Санал дүгнэлт гаргасан	Түвэрт хамруулсан	Аудит хийгээгүй	Үүнээс: Аудит хийсэн хэлбэр	Өөрчлөлтий	Хязгаарлалттай	Сөрөг	Дүгнэлт өгөхөөс татгалзсан
A	1	2	3	4	5	7	8	9	10	
1	ТШЗ		1				1			
	НИЙТ		1				1			

